



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дагшин -Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/4/СТА/ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2020 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

"ДАГ ШИН ЭРДЭНЭ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

2020.03.09 № 1-6/307
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дагшин Эрдэнэ" ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "Дагшин Эрдэнэ" ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Дагшин Эрдэнэ" ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг санхүүгийн тайлан дахь дүн журналын дүнгээс илүү, дутуу илэрхийлэгдсэн, төсвийн байгууллагуудад бэлэн мөнгө гаргаж өгдөг, иргэнээс авсан зээлийг хувь хүнд өгөх өглөгөөр бус харин хувь хүнээс авах авлагаар бүртгэсэн зэрэг 53,850.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

"Дагшин Эрдэнэ" ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын ниитээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ГЭРІ ҮҮЛЭХ АУДИТОР



ЧАРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дагшин -Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Золжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 02-аас 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дагшин -Эрдэнэ ОНӨААТҮГ-ын н 2019 оны санхүүгийн тайланг “Уваа уул аудит” ХХК-д 14-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дагшин -Эрдэнэ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдээ дээдэлсэн, эелдэг, найрсаг, чадварлаг хүний нөөцтэй, байгальд ээлтэй, бизнесийн таатай орчин бүрдсэн, өндөр чадавхи бүхий сувилал байж, өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлж, ашигтай ажиллахад оршино.

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сувилал
- Аялал жуулчлал
- Зочид буудал
- Халуун ус

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2018 онд боловсруулан мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дагшин -Эрдэнэ ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд программ хангамж ашигладаггүй байна.

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 98,930.2 мянган төгрөгөөс тооцон 989.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 989.3 мянган төгрөгөөр тооцсон нь өөрчлөгдөөгүй байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,970.0 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	363.0	19,776.6	19,413.6
Авлага	1,953.4	2,353.7	400.3
Урьдчилгаа			
Бараа материал	67,658.3	68,407.3	749.0
Үндсэн хөрөнгө	441,381.9	384,849.1	-56,532.8
Нийт хөрөнгө	511,356.7	475,386.7	-35,970.0
Өр төлбөр	11,010.3	582.3	-10,428.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	500,346.4	474,804.4	-25,542.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	511,356.7	475,386.7	-35,970.0

Авлага дансанд байгууллагын 3 ажилтнаас 2,353.7 мянган төгрөгийн авлагатай гарчээ. Үүнд: Нярав Д.Эрдэнэчимэгээс оны эхэнд 1,027.0 мянган төгрөгийн авлагатай байснаас 702.1 мянган төгрөгийг тайлант онд барагдуулж, үлдэгдэл 306.9 мянган төгрөг үлдэж, авлага буурсан, Ц.Золжаргалаас 586,8 мянган төгрөгийн авлагатай байсан боловч тайлант онд төлөлт хийгээгүй үлдэгдэл хэвээр байгаа, малчин-сахиул Ч.Батбаатар тайлант онд оюутан хүүхдийн сургалтын төлбөр төлөх шалтгаанаар 1,460.0 мянган төгрөгийг ондоо багтааж төлнө гэж байгууллагаас зээлсэн боловч барагдуулж чадаагүйн улмаас авлага өсөхөд нөлөөлжээ. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон, барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансанд 2019 онд зайлшгүй шаардлагатай 2,779.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор ашиглах хугацаа дуусаж, цаашид ашиглах боломжгүй болсон 3,422.5 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын өмч хамгаалах комиссын хурлын шийдвэрээр акталж данснаас хассан байна. Бараа материалын дансанд ашиглалтгүй, үр ашиггүй бараа материал байхгүй. Бараа материалын нөөц үүсгэсэн асуудал байхгүй.

Үндсэн хөрөнгийн дансны бууралт нь тайлант хугацаанд байгуулсан элэгдэл болон үндсэн хөрөнгө данснаас хасалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансанд 642.7 мянган төгрөгийн эмийн болон дээжийн хөргөгч 2-ыг худалдан авч, дээд байгууллагын шийдвэрээр 9,377.5 мянган төгрөгийн бага оврын трактор, фургон автомашиныг акталж данснаас хассан байна.

Хөрөнгө оруулалтаар, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан, үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй.

Сум хөгжлийн сангийн өр 9,700.0 мянган төгрөг, хувь хүнд төлөх 1,000.0 мянган төгрөг өрийг төлж барагдуулснаар өр төлбөрийн дансны үлдэгдэл 10,428.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 474,804.4 мянган төгрөг болж, 25,542.0 мянган төгрөгөөр буурсан нь 9,377.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан, тус байгууллага 2019 онд 16,164.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас шалтгаалсан байна.

Тус байгууллага 2018 онд 354,509.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бол 2019 онд алдагдал 16,164.5 мянган төгрөг болж буурчээ.

2.9. Бизнес төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ нь тайлант онд 132,426.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 138,774.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 104,8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сувилал	102,716.5	97,716.9	-4,999.6	95,1
Аялал жуулчлал	25,720.1	37,265.3	11,545.2	144.9
Зочид буудал, байр түрээс	410.0	1,958.6	548,6	138.9
Халуун ус	2,580.0	1,833.5	-746,5	71.1
Нийт дүн	132,426.6	138,774.3	6,347.7	104,8

Сувиллын орлого 4,999.6 мянган төгрөгөөр тасарсан нь ЭМД-ын санхүүжилтээр 39,600.0 төгрөгийг авсан боловч 51 даатгуулагчид ЭМД-ын үйлчилгээг хангалтгүй үзүүлсэн /сувилал их эмчгүй ажилласан, сувилуулагчдын өвчний түүхэнд илгээсэн эмчийн бичсэн онош, шинжилгээний бичиг хавсаргаагүй/ гэсэн шалтгаанаар 5,610.0 төгрөгийн акт тавьж, ЭМД-ын санд буцаан төвлөрүүлснээс, аялал жуулчлалын орлого 11,545,2 мянган төгрөгөөр өссөн нь тус сувилалд улс, аймгийн чанартай уулзалт, зөвлөгөөн, арга хэмжээнүүд болсон, тус суманд 2019 онд 27 айлын орон сууц, 80 хүүхдийн дотуур байр баригдаж, барилгын ажилчид удаан хугацаагаар байр түрээсэлснээс, зочид буудал, байр түрээсийн орлого 138,9 мянган төгрөгөөр давсан, тус суманд цэвэр, бохир устай орон сууцууд олноор баригдсанаар халуун усаар үйлчлүүлэгчдийн тоо буурсан, халуун ус нь төвлөрсөн системд холбогдсон боловч өвлийн цагт дулаан алдагдалтай учир үйлчлүүлэгчийн тоо жилээс жилд буурч байгаатай холбоотой халуун усны орлого буурсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл нэмж тодорхойлж, нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 101,750.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 47,894.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 53,856.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2018 онд хийгдсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр 281,278.4 мянган төгрөгийн бууралт үүссэнийг “Орлогын дэлгэрэнгүй тайлан”-д “Дахин үнэлгээний гарз” гэж бүртгэснийг “Сайн аудит” ХХК баталгаажуулсан байна. Иймээс 2019 оны “Санхүүгийн байдлын тайлан” болон “Өмчийн өөрчлөлтийн тайлан”-гийн “Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү” дансны эхний үлдэгдэл 0 байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 181 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 53,856.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 989.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл, тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг СТ дахь дүн журналын дүнгээс дутуу байна.

3.1.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгө буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн үлдэх өртгийг зөв тусгах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

3.2. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг СТ дахь дүн журналын дүнгээс илүү байна.

3.2.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгө буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн үлдэх өртгийг зөв тусгах.

4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Төсвийн байгууллагуудад бэлэн мөнгө гаргаж өгдөг /Аймгийн ИТХ 2440.0, сумын ЗДТГ 3327.0, сумын ЭМТ 1345.0 мянган төгрөг/

3.3.2 Эрсдэл:

Төсвийн хуулийг зөрчих боломжийг дээрх байгууллагуудад олгоно.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

3.4 Өглөг данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Иргэн Баярсайханаас 2019 оны 1, 2-р сард нийтдээ 7,000.0 мянган төгрөгийн зээл авч, 2019 онд бүрэн төлсөн. 2019 оны санхүүгийн тайлангийн тайланд үндсэн зээл өглөгөөр тусгагдсан боловч хүүгийн өглөг бүртгэгдээгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Өглөг дутуу бүртгэгдэнэ. Хүүг төлсөн үед тайлант үеийн зардлаар бүртгэгдэж, зардал илүү илэрхийлэгдэнэ.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

3.3.5 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

3.5 Өглөг данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Иргэн Баясгалангаас 2018 оны 12-р сард 2013 онд 1,000.0 мянган төгрөгийн зээл авч, 2019 онд бүрэн төлсөн. 2019 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд үндсэн зээл өглөгөөр тусгагдсан боловч хүүгийн өглөг бүртгэгдээгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Өглөг дутуу бүртгэгдэнэ. Хүүг төлсөн үед тайлант үеийн зардлаар бүртгэгдэж, зардал илүү илэрхийлэгдэнэ.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

3.6 Урьдчилж төлсөн зардал данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас 2013 онд 3,500.0 /Гурилын цех байгуулах/, 2016 онд 6,500.0 /нөтбүүк, өнгөт принтер, зургийн аппарат худалдан авах/ мянган төгрөг авч, 2019 онд бүрэн төлсөн. 2019 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд үндсэн зээлийг өглөгөөр тусгагдсан боловч хүүгийн өглөг бүртгэгдээгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Өглөг дутуу бүртгэгдэнэ. Хүүг төлсөн үед тайлант үеийн зардлаар бүртгэгдэж, зардал илүү илэрхийлэгдэнэ.

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

3.7 Борлуулалтын орлого данстай холбоотой асуудал

3.7.1 Илрүүлэлт:

Цалингийн урьдчилгааг олгохдоо “Цалингийн урьдчилгаа” дансанд бичээгүй.

3.7.2 Эрсдэл:

Цалингийн урьдчилгаа буруу илэрхийлэгдэнэ.

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

3.6. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

3.6.2 Илрүүлэлт:

Иргэнээс авсан зээлийг Хувь хүнд өгөх өглөгөөр бус харин хувь хүнээс авах авлагаар бүртгэсэн.

3.6.3 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.6.4 Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын 2019 оны 271 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах .

3.6.5 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

Иргэнээс авсан зээлийг Хувь хүнд өгөх өглөгөөр бус харин хувь хүнээс авах авлагаар бүртгэсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69,974,819.59</u>	<u>90,537,571.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	363,037.00	19,776,593.11
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	14,149.00	14,149.00
31110	Төгрөг	14,149.00	14,149.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	348,888.00	19,762,444.11
3121	Төгрөг	348,888.00	19,762,444.11
31213	Арилжааны банк дахь харилцах	348,888.00	19,762,444.11
33	АВЛАГА	1,953,448.59	2,353,669.05
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,613,779.95	2,353,669.05
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	339,668.64	
35	БАРАА МАТЕРИАЛ	67,658,334.00	68,407,309.00
354	Хангамжийн материал	60,124,484.00	60,181,509.00
35450	Барилгын засварын материал		700,000.00
35470	Бусад хангамжийн материал	60,124,484.00	59,481,509.00
35600	Мал амьтад	7,533,850.00	8,225,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>441,381,895.00</u>	<u>384,849,096.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	441,381,895.00	384,849,096.00
391	Газар	30,096,000.00	30,096,000.00
392	Биет хөрөнгө	411,285,895.00	354,753,096.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	252,890,810.00	252,890,810.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	3,089,275.00	11,964,077.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,862,548.00	113,485,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	91,534,116.00	109,277,351.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,446,669.00	81,089,343.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	77,153,185.00	83,517,169.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,298,512.00	58,298,512.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	26,336,527.00	32,249,355.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	135,476,094.00	135,476,094.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	40,575,635.00	49,478,710.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>511,356,714.59</u>	<u>475,386,667.16</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,010,319.13</u>	<u>582,306.53</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,310,319.13	582,306.53
413	Өглөг	1,310,319.13	582,306.53
4136	Бусад өглөг	1,310,319.13	582,306.53
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	310,319.13	582,306.53
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	1,000,000.00	
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,700,000.00	-
422	Урт хугацаат зээл	9,700,000.00	-
4221	Төгрөг	9,700,000.00	-
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	9,700,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>500,346,394.46</u>	<u>474,804,360.63</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	500,346,394.46	474,804,360.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,084,028,229.00	1,074,650,681.00
51101	Өмч: - төрийн	1,084,028,229.00	1,074,650,681.00
512	Хуримтлагдсан үр дүн	(583,681,834.54)	(599,846,320.37)
51220	Тайлант үеийн үр дүн	(583,681,834.54)	(599,846,320.37)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>511,356,713.59</u>	<u>475,386,667.16</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	64,580,871.73	98,860,590.62
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	83,185,058.23	138,774,316.03
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	18,604,186.50	39,913,725.41
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	419,090,143.76	115,025,076.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	137,811,757.76	115,025,076.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,811,757.76	115,025,076.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,884,500.00	40,493,287.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	31,884,500.00	40,493,287.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,659,300.00	4,902,160.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,659,300.00	4,902,160.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,163,242.00	6,414,360.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	5,163,242.00	6,414,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,274,483.00	11,975,136.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	4,589,360.00	6,432,432.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	4,685,123.00	5,542,704.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,830,232.76	51,240,133.45
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	18,604,186.50	39,844,098.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	70,226,046.26	11,396,035.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	281,278,386.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	281,278,386.00	-

225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	281,278,386.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(354,509,272.03)</u>	<u>(16,164,485.83)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(354,509,272.03)</u>	<u>(16,164,485.83)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>109,243,384.00</u>	<u>168,202,530.00</u>
120009	Бусад орлого	26,058,325.77	30,556,194.44
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	83,185,058.23	137,646,335.56
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>110,119,828.00</u>	<u>137,288,973.89</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>110,119,828.00</u>	<u>137,288,973.89</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>110,119,828.00</u>	<u>137,288,973.89</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,884,470.00	40,493,287.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	31,884,470.00	40,493,287.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,659,274.00	4,902,160.88
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,659,274.00	4,902,160.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,163,242.00	6,414,360.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	5,163,242.00	6,414,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,274,483.00	11,975,137.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	4,589,360.00	6,432,432.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	4,685,123.00	5,542,705.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,138,359.00	73,504,029.01
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	81,582.00	2,450,000.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	12,784,810.37	18,289,983.24
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	217,200.00	265,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	48,054,766.63	52,499,045.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(876,444.00)</u>	<u>30,913,556.11</u>
14	Бусад эх үүсвэр	-	10,000,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		10,000,000.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	21,500,000.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		21,500,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	_____	<u>(11,500,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(876,444.00)	19,413,556.11

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,239,481.00	363,037.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	363,037.00	19,776,593.11

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,084,028,229.00	0.00	-938,191,106.51	500,346,394.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,084,028,229.00	0.00	-583,681,834.51	500,346,394.49
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-9,377,548.00			-9,377,548.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			-16,164,485.83	-16,164,485.83
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,074,650,681.00	0.00	-599,846,320.37	474,804,360.63

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.12.31			ДГА-2020/4/СТА-ОНӨААН)
Шалгагдсан байгууллагын нэр:	Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн, сая төг	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг СТдахь дүн журналын дүнгээс дутуу байна.	14,989.3	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
2	Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг СТдахь дүн журналын дүнгээс илүү байна.	24,804.7	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
3	Төсвийн байгууллагуудад бэлэн мөнгө гаргаж өгдөг /Аймгийн ИТХ 2440.0, сумын ЗДТГ 3327.0, сумын ЭМТ 1345.0 мянган төгрөг/	7,112.0	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
4	Иргэн Баярсайханаас 2019 оны 1, 2-р сард нийтдээ 7,000.0 мянган төгрөгийн зээл авч, 2019 онд бүрэн төлсөн. 2019 оны санхүүгийн тайлангийн тайланд үндсэн зээл өглөгөөр тусгагдсан боловч хүүгийн өглөг бүртгэгдээгүй байна.	1,500.0	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
5	Иргэн Баясгалангаас 2018 оны 12-р сард 2013 онд 1,000.0 мянган төгрөгийн зээл авч, 2019 онд бүрэн төлсөн. 2019 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд үндсэн зээл өглөгөөр тусгагдсан боловч хүүгийн өглөг бүртгэгдээгүй байна.	300.0	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
6	Сум хөгжүүлэх сангаас 2013 онд 3,500.0 /Гурилын цех байгуулах/, 2016 онд 6,500.0 /нөөтбүүк, өнгөт принтер, зургийн аппарат худалдан авах/ мянган төгрөг авч, 2019 онд бүрэн төлсөн. 2019 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд үндсэн зээлийг өглөгөөр тусгагдсан боловч хүүгийн өглөг бүртгэгдээгүй байна.	300.0	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
7	Цалингийн урьдчилгааг олгохдоо дансны бичилт буруу хийсэн .	1,850.0	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
8	Иргэнээс авсан зээлийг Хувь хүнд өгөх өглөгөөр бус харин хувь хүнээс авах авлагаар бүртгэсэн.	3,000.0	Зөвлөмж	Захирал нябо	Ц.Золжаргал Ц.Лхагвасүрэн
	ДҮН	53,856.0			